БАТЛАВ:
"ЮНИТЕЛ" ХХК-ИЙН
БАЙГУУЛЛАГЫН БИЗНЕС
ХАРИУЦСАН ДЭД ЗАХИРАЛ
..........................
Б.ЭНХТҮВШИН

БАТЛАВ:
"АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ"
ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
..........................
М.МӨНХӨӨ

# ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ

2023 оны 12-р сарын 11-ны өдөр 2023.12.25 | № Corp/m-23/3021 2023/119 | Улаанбаатар хот

Энэхүү үйлчилгээний гэрээг нэг талаас 5036895 тоот регистрийн дугаартай, Монгол улсын хуулийн этгээд болох "ЮНИТЕЛ" ХХК (цаашид "Үйлчилгээ үзүүлэгч" гэх), түүнийг төлөөлж Байгууллагын борлуулалтын хэлтсийн менежер С.Дуламханд, нөгөө талаас "6021646" тоот регистрийн дугаартай "Амгалан дулааны станц" ТӨХК (цаашид "Үйлчлүүлэгч" гэх), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал албан тушаалтай М.Мөнхөө /хамтад нь "Талууд", дангаар нь зарим тохиолдолд "тал" гэх/ нар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү гэрээгээр Үйлчилгээ үзүүлэгч нь Үйлчлүүлэгч болон түүний салбар нэгжүүд, ажилтнуудыг өөрийн үйлчилгээгээр хангах, Үйлчлүүлэгч нь төлбөрийг төлөх хэлцлийн нөхцөл, түүнтэй холбогдон үүсэх хамтран ажиллах зарчим, гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, дуусгавар болгохтой холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Талууд үйлчилгээтэй холбоотой аливаа мэдээллийг шуурхай солилцох, нууцлалыг хамгаалах зорилгоор дор дурдсан ажилтнуудыг итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилж байгаа бөгөөд үйлчилгээтэй холбоотой аливаа асуудлыг зөвхөн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан шийдвэрлэнэ.

| |
|---|
| Үйлчилгээ үзүүлэгч |
| Албан тушаал: Байгууллагын борлуулалтын менежер<br>Нэр: О.Буянхишиг<br>Утас: 89112888<br>И-мэйл: buyankhishig.o@unitel.mn<br>Албан тушаал: Байгууллага хариуцсан ажилтан<br>Нэр: Ц.Сайн-Өлзий<br>Утас: 89116194<br>И-мэйл: sain-ulzii.ts@unitel.mn |
| Үйлчлүүлэгч байгууллага |
| Албан тушаал: СЭЗХ-ийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч<br>Нэр: Ө.Удвал<br>Утас: 99047300<br>И-мэйл: udval_42@yahoo.com |

1.3. Бүтээгдэхүүн үйлчилгээний үнэ тариф хөнгөлөлт урамшууллын нөхцөлийг хавсралтаар тогтоох ба гэрээний хавсралтууд нь гэрээний салшгүй хэсэг байна.

## ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

2.1 Энэхүү гэрээ нь 2023 оны 12-р сарын 14-ны өдрөөс 2026 оны 12-р сарын 13-ны өдрийг хүртэл 3 (гурав) жилийн хугацаанд хүчин төгөлдөр болно үйлчилнэ.

2.2 Энэхүү гэрээний 2.1-д заасан хугацаа дуусгавар болохоос 30-аас доошгүй хоногийн өмнө талуудаас гэрээг дуусгавар болгох саналаа бичгээр гаргаагүй тохиолдолд энэхүү гэрээг ижил нөхцөлөөр, мөн хугацаагаар сунгагдсанд тооцно.

## ГУРАВ. ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

**3.1Үйлчилгээ үзүүлэгч нь дараах эрхийг эдэлнэ. Үүнд:**

3.1.1 Үйлчлүүлэгч байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг гэрээнд хавсаргуулах;

3.1.2 Үйлчилгээний төлбөрийг хугацаанд нь төлүүлэх;

3.1.3 Шаардлагатай тохиолдолд үйлчилгээг хязгаарлах;

3.1.4 Байгууллагын бүртгэлтэй дугааруудын хувь хэрэглэгчийн мэдээллийг /овог, нэр, РД/ Үйлчлүүлэгч байгууллагаас гаргуулан авах;

3.1.5 Аль нэг талын буруутай үйл ажиллагааны улмаас нөгөө талд хохирол

*Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно.*

учирсан бол учирсан хохирлоо буруутай талаар нөхөн төлүүлэхээр шаардах;

3.1.6 Хэрэглэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд зөвхөн үүргийн гүйцэтгэлийг хангуулах зорилгоор холбогдох байгууллагуудтай хамтран Хэрэглэгчийн мэдээллийг ашиглах үүрэгтэй.

**3.2 Үйлчилгээ үзүүлэгч нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:**

3.2.1 Гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар биелүүлэх;

3.2.2 Хамтын ажиллагааны явцад албан болон албан бусаар мэдсэн байгууллагын нууцыг чандлан хадгалах;

3.2.3 Гэрээний хавсралтад заасан үйлчилгээг чанартай хүргэх;

3.2.4 Үйлчилгээний нөхцөл, үнэ тариф болон гэмтэл саатлын мэдээллээр үйлчлүүлэгч байгууллагыг хангах;

3.2.5 Төлбөрийн нэхэмжлэхийг и-мэйл эсхүл шуудангаар, веб хуудаст байршуулах;

3.2.6 Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн албан хүсэлтийн дагуу үйлчилгээ үзүүлэх;

3.2.7 Байгууллагын багцад хамрагдсан хэрэглэгчийн мэдээллийг нууцлах;

## ДӨРӨВ. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГЫН ЭРХ, ҮҮРЭГ

**4.1 Үйлчлүүлэгч байгууллага нь дараах эрхийг эдэлнэ. Үүнд:**

4.1.1 Үйлчилгээний нөхцөл, үнэ тарифын талаар мэдээлэл авах;

4.1.2 Албан хүсэлт гаргасны үндсэн дээр бүтээгдэхүүн үйлчилгээг сонгох, өөрчлөх, цуцлах;

4.1.3 Үйлчилгээний талаар санал, гомдол гаргаж шийдвэрлүүлэх;

**4.2 Үйлчлүүлэгч байгууллага нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:**

4.2.1 Байгууллагын Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг гэрээнд хавсаргах;

4.2.2 Үйлчилгээг ашиглахгүй болсон тохиолдолд нэн даруй үйлчлүүлэгчид албан хүсэлтээр мэдэгдэх, энэ үүргээ биелүүлээгүйгээс гарсан аливаа эрсдэлийг бүрэн хариуцах;

4.2.3 Байгууллагын хаяг, утас, и-мэйл, итгэмжлэгдсэн төлөөлөгч өөрчлөгдсөн тохиолдол тухай бүр Үйлчилгээ үзүүлэгчид албан бичгээр мэдэгдэх, мэдэгдээгүйгээс үүдэн гарсан аливаа эрсдэлийг бүрэн хариуцах;

4.2.4 Үйлчилгээг зориулалтын бус аргаар эсхүл хууль бусаар ашиглахгүй байх;

4.2.5 Үйлчилгээ үзүүлэгчийн бүтээгдэхүүн, үйлчилгээг гуравдагч этгээдэд дамжуулахгүй байх, бүтээгдэхүүн үйлчилгээний нууцлалыг хариуцах;

4.2.6 Байгууллагын бүртгэлтэй дугааруудын хувь хэрэглэгчийн мэдээллийг /овог, нэр, РД/ Үйлчилгээ үзүүлэгчид бүрэн өгсний үндсэн дээр дугаараа үүсгүүлэх;

4.2.7 Байгууллагын багц дахь дугааруудаас дан байгууллагын эзэмшилд хамрагдах дугаарыг албан тоотоор баталгаажуулж гэрээнд хавсаргах;

4.2.8 Үйлчлүүлэгч нь төлбөр төлөх үүргээ биелүүлээгүй тохиолдолд зээлийн мэдээллийн санд муу зээлдэгчээр бүртгэгдэх ба ингэснээр цаашид бусад худалдаа, санхүүгийн үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагуудаас зээл болон лизинг авах эрхгүй болох эрсдэлтэйг анхаарах үүрэгтэй.

**4.3 Үйлчлүүлэгч дугаарынхаа ярианы дэлгэрэнгүй авах тохиолдолд доорх байдлаар шийднэ.**

4.3.1 Байгууллагын дугаар нь хувь хэрэглэгчийн нэр дээр бүртгэлтэй тохиолдолд хувь хэрэглэгчийн зөвшөөрөлгүйгээр байгууллагад ярианы дэлгэрэнгүйг гаргаж өгөхгүй.

4.3.2 Хувь хэрэглэгчийн бүртгэл үүсэх боломжгүй, давхар бүртгэлтэй дугааруудын ярианы дэлгэрэнгүй хуулгыг авах тохиолдолд үйлчлүүлэгч байгууллагаас албан бичгээр хүсэлт ирүүлсний үндсэн дээр үйлчилгээг үзүүлнэ.

4.3.3 Дэлгэрэнгүй мэдээлэл гэдэгт зөвхөн хэрэглэгчийн гадагш залгасан дугаарууд хамаарна.

## ТАВ. ТӨЛБӨР ТООЦОО

5.1 Үйлчлүүлэгч байгууллагын бүртгэлтэй дараа болон хосолсон төлбөрт дугаарын төлбөрийг тухайн сарын эхний хоногоос сүүлийн хоногийг дуустал хугацаагаар тооцож дараа сарын 10-ны хооронд дугаар бүрд мессежээр болон 1.2-д заасан итгэмжлэгдсэн төлөөлөгчийн и-мэйл хаягаар хүргүүлнэ.

5.2 Үйлчлүүлэгч байгууллага нь төлбөрийн нэхэмжлэхэд заасан төлбөрийг тухайн сарын 20-ны өдрийн дотор дараах дансанд бүрэн төлж дуусгасан байна. Гүйлгээний утга дээр байгууллагын нэр, аль сарын төлбөр болохыг бүрэн бөглөнө.

ХХБ – **470000902** Голомт банк- **2010004330**
Хаан банк-**5038019116**

5.3 Үйлчлүүлэгч байгууллагын дугаар урьдчилсан төлбөрт үйлчилгээтэй бол доорх байдлаар шийднэ.

5.3.1 Үйлчилгээ үзүүлэгч нь Үйлчлүүлэгч байгууллагын хэрэглэгчдийн эхний сарын цэнэглэлтийн мөнгөн дүнг гэрээ байгуулсан өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор и-мэйл эсхүл шуудангаар үйлчлүүлэгч байгууллагын хаягаар хүргүүлнэ. Үйлчлүүлэгч нь төлбөрийн нэхэмжлэхэд заасан төлбөрийг нэхэмжилснээс хойш ажлын 10 хоногт дараах дансанд бүрэн төлөх ба гүйлгээний утга хэсэгт байгууллагын нэр, аль сарын төлбөр болохыг бүрэн бичнэ.

5.3.2 Урьдчилсан төлбөрт бүх дугаар нь 30 хоногийн дотор үйлчилгээний эрхээ идэвхжүүлээгүй тохиолдолд цуцлагдаж, дахин худалдаанд гарна.

5.4 Төлбөртэй холбоотой маргаан үүссэн тохиолдолд Үйлчлүүлэгч нь төлбөрийн нэхэмжлэлд заасан хугацаанд үйлчилгээний төлбөрөө бүрэн төлөх бөгөөд Талууд асуудлыг бүрэн шийдвэрлэсний дараагаар төлбөрөөс хасалт хийлгэх эрхтэй болно.

5.5 Юнител нь энэхүү нөхцөлийн 2.1-д заасан хугацаанд төлбөр нэхэмжлээгүй, эсвэл үндсэн гэрээний 4.2.2-т заасан нөхцөлд үйлчилгээ хаагаагүй нь үйлчлүүлэгчийг төлбөр төлөх үндсэн үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

5.6 Байгууллагын **багцын** үйлчилгээнээс хувь хэрэглэгчийн smartdays үйлчилгээ рүү шилжихэд хэрэглэгчийн дансан дахь үлдэгдэл нэгж өөрчлөгдөхгүй, харин үйлчилгээний хүчинтэй хугацаа устаж, 7 хоног болж өөрчлөгдөнө.

5.7 Дараах тохиолдолд Үйлчлүүлэгч байгууллагад үзүүлсэн хөнгөлөлтийг өөрчилнө.

5.7.1 Эзэмшилдээ буй дугаарын тоог 20 /хорин/ хувь буюу түүнээс дээш хувиар бууруулсан;

5.7.2 Эзэмшилдээ буй нийт дугаарын 50 /тавин/ хувь буюу түүнээс дээш хувийг 3 /гурван/ сараас дээш хугацаагаар хаалгасан;

## ЗУРГАА. ХАРИУЦЛАГА

6.1 Аль нэг тал нь өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас нөгөө талдаа учруулсан хохирлоо нөхөн төлөх үүрэгтэй. Хохирол гэдэгт баримтаар нотлогдсон бодит хохирлыг ойлгоно.

6.2 Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй эсхүл зохих ёсоор биелүүлээгүй байх нь хариуцлага тооцох үндэслэл болно.

6.3 Үйлчлүүлэгч байгууллага нь гэрээнд заасан үүргээ хугацаандаа биелүүлээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.3 хувийн алданги тооцно.

6.4 Хэрэглэгчийн хэрэглээ, үйлдлээс шалтгаалсан төлбөр болон ашиглаж байгаа гар утас, тоног төхөөрөмжөөс шалтгаалсан үйлчилгээний доголдлыг Үйлчилгээ үзүүлэгч хариуцахгүй.

6.5 Газар зүйн хувьд хэт алслагдмал, газар дор байрлалтай, эсхүл зузаан бетон хананд халхлагдсан тодорхой нутаг дэвсгэрт сүлжээ доголдож болох бөгөөд үүнтэй холбогдон үүсэх аливаа хохирлыг Үйлчилгээ үзүүлэгч хариуцахгүй.

6.6 Үйлчлүүлэгч байгууллага нь бүтээгдэхүүн үйлчилгээгээ гуравдагч этгээдэд ашиглуулсан, аль нэг программыг буруу ажиллуулсан эсхүл хууль бус үйл ажиллагаанд ашигласан тохиолдолд түүнээс үүдэн гарах аливаа үр дагавар, хохирлыг бүрэн хариуцна.

6.7 Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлсийн улмаас талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй эсвэл зохих ёсоор биелүүлээгүй бол хариуцлага хүлээхгүй болно.

6.8 Холбогдох хууль тогтоомжид заасан гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлсийн улмаас талуудын аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол нөгөө талдаа ажлын гурав хоногийн дотор бичгээр мэдэгдэх ба энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.

## ДОЛОО. ГЭРЭЭНД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, ГЭРЭЭГ ЦУЦЛАХ БОЛОН ДУУСГАВАР БОЛГОХ ҮНДЭСЛЭЛ

7.1 Энэхүү гэрээнд гагцхүү талуудын харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр хийсэн гэрээний хэлбэрээр нэмэлт, өөрчлөлт оруулах бөгөөд эх хувьд баллаж засварласан буюу бусад аргаар оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлтийг хүчингүйд тооцно.

7.2 Аль нэг нь энэхүү гэрээнд заасны дагуу гэрээг хугацаанаас өмнө цуцлах эсвэл гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хүсвэл энэ тухайгаа нэг сараас доошгүй хугацааны өмнө нөгөө талд албан бичгээр мэдэгдэнэ.

7.3 Энэхүү гэрээг аль нэг талын санаачилгаар үндэслэлгүйгээр цуцлахыг хориглох бөгөөд дараах тохиолдолд гэрээг цуцалж болно.

7.3.1 Талууд харилцан тохиролцсоны дагуу гэрээг цуцлах;

7.3.2 Аль нэг тал нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа биелүүлээгүй тохиолдолд нөгөө тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх талаар шаардлага хүргүүлэх бөгөөд

*Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно.*

шаардлагад дурдсан хугацаанд үүргээ биелүүлээгүй бол;

7.4 Энэхүү гэрээний хугацаа дууссан, эсхүл аль нэг тал нь эрх зүйн чадамжгүй болсон, энэхүү гэрээнд заасны дагуу гэрээ цуцлагдсан тохиолдолд гэрээ дуусгавар болно.

## НАЙМ. БУСАД ЗҮЙЛ

8.1 Гэрээг хоёр хувь үйлдэж тал тус бүр нэг хувийг хадгалсан нь хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

8.2 Талуудын үүсгэн байгуулагчид, Гүйцэттэх захирал өөрчлөгдсөнөөс үл хамааран энэхүү гэрээ нь 2.1 д заасан хугацаанд хүчин төгөлдөр байна.

8.3 Энэхүү гэрээтэй холбоотой асуудлаар ямарваа маргаан гарсан тохиолдолд талууд зөвшилцлийн аргаар асуудлыг шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Хэрэв нэгдсэн шийдэлд хүрч чадахгүй тохиолдолд хуулийн байгууллагад хандах эрх нь аль ч талд нээлттэй байна.

8.4 Энэхүү гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсан этгээдийг талууд энэ асуудлаар өөрийн байгууллагыг төлөөлөх бүрэн эрхтэй хэмээн үзэх бөгөөд хуулиар ийм эрх олгогдоогүй этгээд гэрээнд гарын үсэг зурсан нь энэхүү гэрээг хүчин төгөлдөр бусад тооцуулах, үүсэх эрсдэлийг хариуцахгүй байх үндэслэл болохгүй.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

Үйлчилгээ үзүүлэгчийг төлөөлж:

БАЙГУУЛЛАГЫН БОРЛУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН МЕНЕЖЕР

........................................ /Г.ДУЛАМХАНД /

БАЙГУУЛЛАГЫН БОРЛУУЛАЛТЫН МЕНЕЖЕР

........................................ /О.БУЯНХИШИГ /

Хаяг:
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо
Сүхбаатарын талбай-2, Сэнтрал тауэр,
14 давхар.
Утас: 77778080, Факс: 77778989

Үйлчлүүлэгч байгууллагыг төлөөлж:

СЭЗХ-ИЙН ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

........................................ /Ө.УДВАЛ/

АЖ АХУЙ, ХАНГАМЖИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

........................................ /Г.БАТТУЛГА/

ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН

........................................ /Г.САРУУЛ/

Хаяг:
Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 8-р хороо,
УС-15

Утас: 77111252, 77111244

*Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно.*